

ТЭРГҮҮН

**АЗИ, НОМХОН ДАЛАЙН БҮС
НУТГИЙН ЭНХ ТАЙВАН,
АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТӨЛӨӨ**

Орчин үе бол шинжлэх ухаан техникийн хувьсгалын нөр их ололт хамгаас түрүүн цэрэг, зэвсэглэлд нэвтэрч, хэрэв дайн дэгдвэл, манай гариг, хүн төрөлхтний соёл иргэншил халуун цөмийн сүйрэлд нэгмөсөн өртөх нэн аюултай үе болжээ.

Хэдийгээр хүн төрөлхтөн бүхэлдээ биш ч гэсэн түүний зарим хэсэг ийм аюулыг нэгэнт бий болгосон болохоор уураг тархины дээд хөгжил, ухамсарлан бодох ухаан санаагаараа гойд тодорсон хүн төрөлхтөн өөрөө л гагцхүү уг аюулыг зайлуулж чадна.

Пуужин-цөмийн энэ эрин үед нийгмийн эсрэг тэсрэг хоёр систем социализм, капитализмын түүхэн уралдаан, нийгэм-эдийн засгийн янз бүрийн байгуулалтай улсуудын хоорондын аливаа маргааны асуудлуудад үеэ өнгөрөөсөн цэрэг, зэвсгийн хүчээр айлган сүрдүүлэх буюу хүч хэрэглэж ирсэн хуучин сэтгэлгээгээр хандах явдлаас үүрд ангижирч, харин харилцан ярилцаж тохиролцон, бие биеийнхээ аюулгүй байдлыг адил тэгш үндсэн дээр хангах үүднээс харилцан буулт хийж, тэдгээрийг улс төрийн аргаар зохицуулан шийдвэрлэж байх шинэ сэтгэлгээнд бүх нийтээр шилжин орох нь одоо цагийн хүн төрөлхтөн, түүний хойч үеийнхний амин чухал эрх ашигт бүрэн дүүрэн нийцсэн хамгийн ухаалаг, оновчтой зөв арга зам мөн.

Ийм шинэ сэтгэлгээ, соргог үзэл санааны дор өнгөрсөн онд хуралдсан ЗХУКН-ын XXVII их хурал, МАХН-ын XIX их хурал болон ах дүү социалист бусад орны коммунист, ажилчны намуудын их хурлуудын шийдвэрт орчин үеийн олон улсын бүх нийтийг хамарсан аюулгүй байдлын систем тогтоох талаар ЗХУ-ын дэвшүүлсэн оновчтой саналыг хэрэгжүүлэх нь, дэлхийн бүх улс орон, нийт хүн төрөлхтний чин эрмэлзлэлд нийцэж байгааг заасан юм.

Дэлхийн бөмбөрцгийн хуурай газрын 60 хувийг эзэлдэг, нийт хүн төрөлхтний тэн хагасаас илүү нь оршин амьдардаг өргөн уудам Ази Тив дэлхийн хамгийн том усан-Номхон далайн бүс нутагт аюулгүй байдлыг хангах нь дэлхий дахиныг хамарсан аюулгүй байдлын систем тогтооход ихээхэн чухал байр суурь эзлэх асуудал билээ.

Тус бүс нутаг нь дэлхийн нэн түгшүүртэй район болж байгаа бөгөөд чухам энд л халуун цэг, орон нутгийн мөргөлдөөний олонхи нь байна.

Империалист харгис хүчин энэ бүс нутгийг Дэлхийн социализм, олон улсын коммунист, ажилчны болон үндэсний эрх чөлөгний хөдөлгөөн, улс түмний нийгмийн хөгжил дэвшлийн эсрэг тэмцэлд Европын дараах пуужин-цөмийн болон бусад төрлийн зэр зэвсгийн бөөгнөрлийн талбар болгон ашиглахыг улайран оролдож байна. Чухам энд л Америкийн империализм хүн төрөлхтний түүхэнд анх удаа атомын бөмбөг хэрэглэж, Японы тус бүр хэдэн зуун мянган оршин суугч бүхий Хиросима, Нагасаки хотуудыг үнсэн товрог болгож, дэлхийн I дайнаас хойш олон удаа зэвсгийн хүч хэрэглэн түрэмгийлэл үйлдсний дотор Солонгос, Вьетнамын ард түмний ихээхэн цус урсгасан хоёр дайн хийсэн юм.

Сүүлийн жилүүдэд АНУ «дэлхий дахиныг хамарсан» бодлогынхоо дагуу Ази, Номхон далайн бүс нутгийг цэрэгжүүлэх ажлаа өргөн хэмжээгээр их хурдацтай идэвхжүүлж, цэрэг зэвсгийн хүчээ нэмэгдүүлэн, пуужин-цөмийн зэвсэг бүхий тэнгисийн төрөл бүрийн хөлөг онгоц, бөмбөгдөгч онгоцууд бөөгнөрүүлж, цэргийн бааз, түшиц газруудыг төв ко-

мандлал гэдгийн командын дор «түргэн хөдлөх» хүчиндээ зориулан улам олноор байгуулах боллоо. Ази, Номхон далайн бүс нутагт АНУ-ын 3,7-р флот байрладаг бөгөөд эдгээрийн байлдааны хүчин чадлыг Америкийн засаг захиргаа сүүлийн жилүүдэд эрс нэмэгдүүлж байна. Энэ хоёр флотыг атомын хөдөлгүүртэй шумбагч, нисэх онгоц тээгч, дэмжигч зэрэг байлдааны янз бүрийн зориулалттай тэнгисийн олон арван хөлөг онгоцоор хүч сэлбэсэн бөгөөд тус бүс нутагт байрлаж буй Америкийн цэргийн тоо 360 мянгад хүрчээ. Тэдний байрлаж байгаа олон тооны объект, баазын дотроос АНУ-ын цэргийн стратегид ЗХУ болон социалист бусад оронд цохилт өгөх гол түшиц газар болгон Япон, Өмнөд Солонгосыг ашиглахад онцгой анхаарч байна. Японд Америкийн олон арван мянган цэрэг бүхий 120 шахам бааз, Өмнөд Солонгост 40 мянган цэрэг бүхий 40 бааз байрлаж байгаа юм.

АНУ-ын эрх баригчид Японы засгийн газар, Өмнөд Солонгосын харгис дэглэмтэй цэрэг-улс төрийн гурвалсан холбоог бий болгон, Ази, Номхон далайн бүс нутагт түрэмгий бодлогоо хэрэгжүүлэх гол тулгуур хүч болгон ашиглахыг эрмэлзэж байна. Ялангуяа эдийн засгийн хүчирхэг потенциал, түргэн өсөн нэмэгдэж байгаа зэвсэгт хүчин бүхий Япон улсыг АНУ-ын эрх баригчид Ази, Номхон далайн районд цэрэг дайны ажиллат явуулах гол тулгуур хүч гэж үзэж, түүнийг Америк-Японы «аюулгүйн гэрээ» гэгчээр урихандаа оруулаад Японы милитаризмыг улам бүр сэргээж байна. АНУ-ын милитарист бүлгийнхний шахалтаар Японы эрх баригчид дайны дараах үндсэн хуулийн 9-р зүйлийг умартаж, улс орондоо цэрэг дайны хэнээрхлийг дэгдээн цэргийн төсөв зардлаа байнга нэмэгдүүлж ирэв. Хэрэв 70-аад оны дунд үед японы цэргийн шууд зардал 1 триллион 330 миллиард шахам иен байсан бол 1986 онд 3 триллион 343 миллиард 500 сая иен болж өсчээ. Японы эрх баригчид ийнхүү цэргийн зардлаа ихээхэн нэмэгдүүлсний учир бол Ази, Номхон далайн районд АНУ-ын цэргийн төсөв зардлыг хэмнэн өөр зэвсэглэл (тухайлбал «Оддын дайны» программ)-д зориулахад тус дөхөм үзүүлж буй хэрэг мөн. Япон улс «өөрийгөө батлан хамгаалах хүч» гэдэг халхав чийн дор милитаризмыг сэргээж, хамгийн орчин үеийн зэвсэг техникээр хангагдсан армитай болжээ. Одоо Японы зэвсэгт хүчин 250 мянган хүнтэй болж, армия зэвсэглэсэн байдал, байлдааны ажиллагааг явуулах бололцоо, түүний зэвсгийн галын хүч чадал зэргээрээ милитарист Японы үеийн эзэн хааны армийнхаас даруй хэдэн арав дахин давуу болж, хөрөнгөтөн орнуудын армийн дотор 6-р байранд орж байгаа ажээ. Япон улсын цэргийн аж үйлдвэр нь армия залуурт пуужин, орчин үеийн танк, сөнөөгч— бөмбөгдөгч онгоц, тэнгисийн хамгийн орчин үеийн миньт хөлөг онгоц, шумбагч хөлөг онгоц, хамгийн сүүлийн үеийн электрон тоног техөөрөмжөөр хангаж байна. Цэргийн зарим төрлийн зэвсэг үйлдвэрлэх талаар Япон улс нь хөрөнгөтөн ертөнц дотроо зөвхөн АНУ-ын дараа орж байна. Америк— японы «аюулгүйн гэрээ»-гээр зөвхөн АНУ Японд тусламж үзүүлээд зогсох биш, харин АНУ-аас дэлхий дахинд цэрэг стратегийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд Япон улс бас хамтран оролцох үүрэг хүлээж байгаа нь тодорхой. Ялангуяа АНУ-ын засаг захиргаанаас дэлхий дахины бодлогыг хэрэгжүүлэх, зэвсэглэлээр хөөцөлдөхийн шинэ үе шат болсон сансрыг зэвсэглэх «Оддын дайны» программыг биелүүлэхэд Японы засгийн газар өнгөрсөн оны намар албан ёсоор нэгдэж орсон нь Ази, Номхон далайн бүс нутгийн улс түмнээр үл барам нийт хүн төрөлхтний сэтгэл санааг түгшүүлсэн нэн осолтой бодлого мөн.

Үүний зэрэгцээ АНУ-ын эрх баригчид Алс Дорнод, Номхон далайн сав газарт цэрэг дайны бэлтгэлээ хангах, зэвсэгт мөргөлдөөн дэгдээхэд

Өмнөд Солонгосын харгис дэглэмийг түншээ болгож байна. Вашингтоны засаг захиргаа Солонгосын хойгийг АНУ-ын «амин чухал ашиг сонирхол»-ын район гэж зарласан нь санамсаргүй зүйл бишээ. Учир нь Өмнөд Солонгос бол АНУ-ын хувьд Дорнод Азийн эх газарт үлдсэн цэрэг-улс төрийн цорын ганц түшиц газар юм. Өмнөд Солонгос нь үнэндээ америкийн цөмийн зэвсгийн бааз болж хувирчээ. Тэнд АНУ цөмийн 1000 гаруй нэгж зэвсэг, тэдгээрийг байнд хүргэх «Ф— 16» сөнөөгч-бөмбөгдөгч онгоцууд болон бусад хэрэгсэл байна. Үүний хамт АНУ-ын засаг захиргаа Өмнөд Солонгост оператив — тактикийн «Лэнс» пуужингуудыг байрлуулах шийдвэрийг өнгөрсөн оны 11-р сард гаргаж, Алс Дорнодын байдлыг улам ээдрээтэй хурцадмал болгож байна. Түүгээр ч барахгүй Пентагоны стратегчид Өмнөд Солонгосын харгис дэглэмд армия бэхжүүлэхэд нь идэвхтэй дэмжлэг үзүүлсний дүнд одоо Өмнөд Солонгосын арми 600 мянган хүнтэй болжээ. Мөн нөгөөтэйгүүр Япон улс хэдийгээр Сеулын дэглэмтэй албан ёсоор цэргийн гэрээгээр холбогдоогүй боловч АНУ-ын шахалтаар түүний зэвсэгт хүчнийг байлдааны арга тактикт сургах, армийг нь орчин үеийн зэвсэг техникээр хангах, түүнд санхүүгийн болон бусад тусламж үзүүлэх зэргээр түүний цэргийн потенциалыг нэмэгдүүлэхэд үлэмж хувь нэмэр оруулж байгаа ажээ. ЗХУ, БНАСАУ-ын хилийн ойролцоо Америк— Японы болон Америк — Өмнөд Солонгосын цэргийн хамтарсан хээрийн сургуулийг байнга хийж байна.

АНУ-ын засаг захиргаа НҮБ-ын дүрэм, асрамжийн тухай энэ байгууллагын 1947 оны хэлэлцээр, колони орон, ард түмэнд тусгаар тогтнол олгох тухай НҮБ-ын тунхаглалын заалт, үзэл санааг дур мэдэн зөрчиж, НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн ар хударгаар НҮБ-ын асрамжийн нутаг дэвсгэр болох Микронезийн арлуудын гурван хэсгийг, тухайлан Умард Марианы арал, Маршаллын арал, Микронезийн холбооны муж улсыг АНУ-тай чөлөөтэй нэгдсэн» муж улсын статустай болгож байгаа тухайгаа өнгөрсөн оны 11-р сарын эхээр зарлан, хуулийн ямарч үндэсгүй, олон улсын эрхийн хэм хэмжээнд эрс харш шийдвэр гаргав. НҮБ-ын асрамжийн нутаг— Микронезийг тусгаар тогтнох хүртэл нь олон улсын хамтын нийгэмлэгийн өмнөөс захирч байх эрхийг АНУ-д олгосныг Цагаан ордон өөрийн хар амиа бодсон империалист ашиг сонирхолд захируулан түүнийг өөртөө хүчээр хавсарган нэгтгэх бодлого явуулж, түүнийг хэрэгжүүлсний гол шалтгаан нь чухамхүү тус арлуудын стратегийн чухал байрлалыг харгалзан, АНУ Номхон далайн баруун хэсэгт цэрэг-стратегийн түшиц газар олж авахад чиглэжээ. Микронезийн арлуудад АНУ-ын агаарын болон тэнгисийн цэргийн хэд хэдэн бааз байрлаж, сүүлийн үед Мариан, Палау арал дээр тэнгисийн цэргийн том боомт, стратегийн нисэх онгоцны буудал, нефть хадгалах байр, цэргийн сургуулийн талбай, материал хэрэгслийн агуулах зэргийг барьж байгуулж байгаа ажээ. Харин Маршаллын арлын зарим хэсэгт атом, устөрөгчийн бөмбөгийн туршилт хийж байснаа одоо америкийн баллистик пуужин турших талбай болгожээ.

Ази, Номхон далайн бүс нутагт түгшүүртэй байдал улам даамжирч байгаа өнөө үед АНУ Микронезийн арлуудын гурван хэсгийг өөртөө хүчээр нэгтгэж, Микронезийг Пентагоны цэрэг-улс төрийн түшиц газар болгон хувиргаж байгаа нь тус бүс нутгийн улс орнууд, тэдгээрийн ард түмний төдийгүй нийт дэлхий дахины улс түмний энх тайван, аюулгүй байдалд ноцтой заналхийлж байна.

АНУ Номхон далайн өмнөд хэсгийн 13 улс, бие даасан нутаг орны хооронд Номхон далайн өмнөд хэсгийг цөмийн зэвсэггүй бүс болгох тухай байгуулсан Паротонгын гэрээг ч ойшоохгүй, харин Америкийн цөмийн зэвсэг тээсэн тэнгисийн хөлөг онгоцыг нутгийнхаа усан боомтод оруулахгүй байгаа Шинэ Зеланд, Америкийн цөмийн зэвсгийн туршилтыг зогсоохыг шаардаж буй Австрали болон дээрх гэрээнд гарын үсэг зурсан бусад оронд элдэв дарамт, хавчилт үзүүлж байгаа явдал нь олон улсын эрхийн хэм хэмжээнд нийцэхгүй байгаагаар үл барам үнэн хэрэгтээ энэ районы улс түмний энх тайван, аюулгүй байдалд заналхийлсэн хэрэг юм.

Зүүн Өмнөд Азийн орнуудын хувьд ч АНУ-ын бодлого нь тус бүс нутгийн Индонез, Бруней, Малайз, Сингапур, Тайланд, Филиппин улсуудын эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллага болох АСЕАН-ыг цэрэг-улс төрийн шинжтэй болгохыг эрмэлзэн, Филиппин дэх цэргийн баазаа тус орны дотоод хэрэгт оролцож дарамт үзүүлэх зэвсэг болгон ашиглахад чиглэж байна. Энэтхэг-Хятадын хойгийн орнуудын талаар АНУ нь Социалист Вьетнам, ардчилсан Лаос улс, БН Кампучи Ард Улсын эсрэг Тайландын цэргийн дэглэмтэй эвсэж, цэргийн бэлтгэл хүмүүсийн тухай» гэгч хэлэлцээр байгуулсан нь Зүүн Өмнөд Азийн районд социализмыг шууд заналхийлсэн түүний ажил явуулгын тод баримт юм.

Номхон далайтай холбогдож буй Энэтхэгийн далайн район, Өмнөд болон Баруун өмнөд Азийн орнуудын талаар АНУ-ын явуулж буй бодлого, ялангуяа Диего-Гарсия арлыг цэргийн бааз болгон хувиргаж, тэнд цөмийн болон бусад зэвсэг техник бүхий байлдааны хөлөг онгоцуудыг үлэмж хэмжээгээр байрлуулсан нь улс түмний энх тайван, аюулгүй байдлын эрх ашигт илт харшилж байна. Энэ бүс нутгийн энх тайван, аюулгүй байдлыг сахин бэхжүүлэхэд хоёр жилийн өмнө Энэтхэг, Пакистан, Шри Ланка, Бутан, Балба, Мальдивын Бүгд Найрамдах Улс хамтран байгуулсан «Өмнөд Азийн орнуудын бүс нутгийн хамтын ажиллагааны холбоо» хэмээх байгууллагын үйл ажиллагаа үр дүнгээ өгөх ёстой.

Америкийн цэргийн стратегид Баруун өмнөд Азид Пакистаны цэргийн дэглэмтэй нягт хэлхээ холбоо тогтоож, түүнд цэргийн зэвсэг техник, мөнгөн санхүүгийн ихээхэн тусламж үзүүлэн, Пакистаныг цөмийн зэвсэгтэй болох байдалд хүргэжээ. Энд АНУ Пакистаны цэргийн дэглэмтэн хуйвалдан, Афганистаны хувьсгалын эсэргүүчүүдэд элдэв дэмжлэг үзүүлж БНААфгУ-ын эсрэг зарлаагүй дайныг олон жилийн турш тухирч ирэв. Бүр сүүлийн үед Афганистаны байдлыг энх тайван арга Хэлэлцээний замаар зохицуулах гэсэн Афганистаны нам, засгийн газрын дэвшүүлэн тавьсан үндэсний эвлэрлийн бодлогын саналыг хэрэгжүүлэх явдлыг ч АНУ, Пакистаны эрх баригчид аль болохоор тасалдуулахыг оролдож байна.

Ази, Номхон далайн бүс нутгийн энх тайван, аюулгүй байдлын эрх ашиг ийнхүү АНУ тэргүүтэй империалист харгис хүчний дайнч түрэмгий бодлогын уршгаар ноцтой хохирч, уг аюул заналыг арилгах бодит арга замыг тус бүс нутгийн улс түмэн зүй ёсоор эрэлхийлж байгаа юм. Учир нь тус бүс нутгийн улс орнууд, тэдгээрийн ард түмэн орчин үеийн олон улсын харилцааг шудрага ардчилсан үндсэн дээр өөрчлөн явуулах явдлыг улам бүр ухамсарлан ойлгож, хамтын чармайлтаар цөмийн сүйрлийн аюулыг зайлуулах, энх тайван нөхцөлд өөрсдийнхөө нийгэм-эдийн засгийн олон тооны хойшлуулшгүй асуудлыг нааштай шийдвэрлэхийг үнэнхүү зорьж байна. Энэ зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэ-

сэн тус бүс нутгийн улс орнуудаас олон чухал санал санаачилга гарсны дотор Ази, Номхон далайн бүс нутагт эндэхийн бүх улс түмнийг хамарсан аюулгүй байдлын систем тогтоох талаар ЗХУ-ын дэвшүүлсэн цогцолбор программ нь хамгийн оновчтой, нэн чухал ач холбогдол бүхий санаачилга мөн.

Ялангуяа Ази, Номхон далайн бүс нутагт аюулгүй байдлын систем тогтоох асуудлаар өнгөрсөн оны 4-р сард Зөвлөлт засгийн газрын гаргасан мэдэгдэл, мөн оны 7-р сард Владивостокт ЗХУКН-ын Төв Хорооны Ерөнхий нарийн бичгийн дарга М.С. Горбачёвын хэлсэн үгэнд уг системийг тогтоож болох арга замыг тодорхойлон, Зөвлөлт-Энэтхэгийн удирдагчдын хамтран гаргасан Делийн тунхаглалд цөмийн зэвсэггүй, хүчирхийлэлгүй энх тайвныг бий болгох тухай дурдсан заалт нь тус бүс нутгийн улс түмний талархал дэмжлэгийг олсон билээ.

Ази, Номхон далайн том гүрнүүдийн нэг ЗХУ Алс Дорнод болон нийт Ази тив, түүнд хамаарагддаг далайнуудын өргөн уудам районд аюулгүй байдлыг хангаж, эрх тэгш, харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэн бэхжүүлэх явдлыг өөрийн үндэсний ба улсын эрх ашиг, улмаар тус бүс нутгийн улс орнууд, тэдгээрийн ард түмэн, нийт хүн төрөлхтний ашиг сонирхол, дэлхий дахины энх тайван, аюулгүй байдлыг сахин бэхжүүлэх үйлсэд үлэмжийн чухал байр суурь эзлэх асуудал гэж үзэж байна. ЗХУ энэ талаар чухал санал санаачилгыг зөвхөн дэвшүүлэн гаргаад зогсдоггүй, харин тэдгээрийг хэрэгжүүлэх бодитой практик алхмуудыг боловсруулан, өөрөөсөө шалтгаалах зарим тодорхой арга хэмжээ авч үлгэр дууриал үзүүлж байдгаараа онцлог юм. Юуны өмнө Ази, Номхон далайн бүс нутгийн дотроос цэрэг, зэвсгийн хүч хамгийн их бөөгнөрсөн Алс Дорнодын хурцадмал байдлыг зөөлрүүлэх үүднээс Зөвлөлт-Америк, Зөвлөлт-Японы харилцааг хэвийн болгох, БНХАУ-тай байгаа бололцоог улам дүүрэн ашиглан сайн хөршийн харилцааг хөгжүүлэн бэхжүүлэх, тус бүс нутаг дахь тэнгисийн цэргийн зэвсэглэлийн идэвхжлийг бууруулах, БНМАУ-д Монголын засгийн газрын хүсэлтээр байрлаж буй зөвлөлтийн цэргийн нэлээд хэсгийг манай улстай тохиролцсоны дагуу гаргасан зэргийг энд дурдахад хангалттай юм.

ЗХУ, Ази, Номхон далайн бүс нутгийн аюулгүй байдлыг хангахад чиглэсэн тус бүс нутгийн бусад улс орны санал санаачилгыг идэвхтэй дэмжиж байгаа нь энх тайван, аюулгүй байдлын төлөө энэ районы улс түмний тэмцлийг улам идэвхжүүлж байна.

Ази, Номхон далайн районы орнуудын харилцаанд хүч хэрэглэхгүй механизмыг бий болгох талаар манай улсын дэвшүүлсэн санал, ялангуяа аюулгүй байдлын систем тогтоох талаар энэ районы улс орнуудыг хамарсан чуулга уулзалт хийх, үүнтэй холбогдуулан энэ оны зун Улаанбаатар хотноо Ази, Номхон далайн орнуудын коммунист, ажилчны намуудын төлөөлөгчдийн зөвлөлдөх уулзалтыг зохиох гэж байгаа, НҮБ-ын Ерөнхий Ассамблейн чуулганаар манай улсын оруулсан «Улс түмэн энх тайван амьдрах эрхийн тухай» тунхагийг баталсан зэрэг нь Ази, Номхон далайн бүс нутгийн болон дэлхийн олон улс орны засгийн газар, дэвшилт олон нийт, ард түмэн, олон улсын олон байгууллагын дэмжлэг олж байна.

Алс Дорнод дахь Солонгосын хойгийн түгшүүртэй байдлыг намжаахад БНАСАУ-ын дэвшүүлж буй оновчтой саналууд, тухайлан: Солонгосын хойгийг цөмийн зэвсэггүй бүс болгох, Өмнөд Солонгосоос гадаадын цэргийн бааз, цэргийг гаргах, БНАСАУ, Өмнөд Солонгосын хооронд үл довтолох тухай гэрээ байгуулах, тэдгээрийн дээд хэмжээнд

болон парламентуудын хооронд уулзалт хэлэлцээ хийх, эдийн засгийн харилцааг хөгжүүлэх замаар Солонгосын хойд, өмнөд хэсгийг энх тайвнаар ардчилсан үндсэн дээр гаднын ямарч оролцоогүйгээр шийдвэрлэх зэрэг саналыг тавьсан нь социалист орнууд, дэлхийн дэвшилт олон нийт, энхийг эрхэмлэгч улс түмний талархлыг хүлээж байна.

Ази, Номхон далайн бүс нутагт аюулгүй байдлын систем тогтоох асуудалд тус бүс нутгийн олон зуун сая хүн ам бүхий гүрэн—БНХАУ-ын байр суурь их чухал ач холбогдолтой юм. БНХАУ-ын засгийн газар цөмийн зэвсгийг хорогдуулан хориглож устгах асуудалд нааштай байр суурь баримталж байгаа бөгөөд цөмийн зэвсэгтэй гүрнүүдийн дотроос ЗХУ, БНХАУ хоёр л цөмийн зэвсгийг түрүүлж хэрэглэхгүй үүрэг авч, Номхон далайн өмнөд хэсгийг цөмийн зэвсгээс чөлөөтэй бүс болгох тухай байгуулсан Раротонгын гэрээний хавсралт 2.3-р протоколд нэгдэн орсон нь дэлхийн янз бүрийн районд цөмийн зэвсэггүй бүс байгуулахад улс түмний тэмцлийг дэмжсэн чухал алхам юм. Үүний хамт БНХАУ-ын засгийн газар Ази, Номхон далайн бүс нутагт АНУ-ын зэвсэгт хүчин улам нэмэгдэж, Японд милитаризм сэргэн, тус бүс нутгийн харгис дэглэмтэй хамтарч Пентагоныхан цэргийн хээрийн сургууль хийж байгаа, АНУ-ын засаг захиргааны «стратегийн батлан хамгаалах санаачилга» зэргийг эсэргүүцэж байна. БНХАУ нь цөмийн зэвсэгтэй гүрнүүдийн дотроос энэ зууны эцэс гэхэд дэлхий дахины хэмжээгээр цөмийн зэвсгийг хорогдуулан хурааж устгах тухай өнгөрсөн оны 1-р сарын 15-нд ЗХУ-ын дэвшүүлсэн программыг нааштай үзэж байгаа орон юм. Мөн дэлхийн шинэ дайны аюулыг сэрэмжлэн зайлуулахын материаллаг нөхцөлийг зэвсэг хураах явдал гэж Хятадын удирдлага үзэж байна. БНХАУ Цөмийн зэвсгийн туршилтыг агаар мандалд хийхгүй тухайгаа өнгөрсөн оны 3-р сарын 21-нд мэдэгдсэн юм. Өөрөөр хэлбэл зэвсэглэлээр хөөцөлдөх явдлыг зогсоох, сансрыг зэвсэглэхгүй байх, химийн зэвсгийг хориглох, Энэтхэгийн далайг цөмийн зэвсэггүй бүс болгох, Европ, Ази дахь цөмийн пуужингуудыг хорогдуулан устгах зэрэг орчин үеийн олон улсын харилцааны зарим чухал асуудлаар БНХАУ-ын баримталж буй байр сууринд нэлээд өөрчлөлт гарч байна. Эдгээр нааштай өөрчлөлт нь Ази, Номхон далайн бүс нутагт энх тайван, аюулгүй байдлыг бэхжүүлэх талаар шийдвэрлэгдээгүй үлдэж байгаа бусад олон асуудлыг нааштай шийдвэрлэхэд нөлөөлөх зүйл билээ. Харин БНХАУ-ын гадаад бодлогод орчин үеийн олон улсын байдал хурцадмал байгаагийн бурууг «хоёр хэт их гүрэн» (АНУ, ЗХУ)-д тохон социалист ЗХУ, империалист АНУ хоёрын бодлогыг адилтгасан хэвээр буйгаас гадна Ази, Номхон далайн бүс нутгийн улсуудын хооронд үл довтолох, тэдгээрийн харилцаанд хүч үл хэрэглэх тухай конвенц байгуулах, түүнчлэн Азийн аюулгүй байдлын асуудлаар нийт Азийн чуулга, уулзалтыг хийх талаар манай улсын дэвшүүлсэн санал болон тус бүс нутгийн улсуудын аюулгүй байдлыг хангах, тэдний хооронд харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэн бэхжүүлэхэд чиглэсэн бусад зарим орны чухал санал санаачилга, тэдгээрийн ач холбогдлыг сайтар анхаарахгүй тал байгаа юм.

Ази, Номхон далайн бүс нутагт аюулгүй байдлын систем тогтооход Зүүн өмнөд Ази дахь түгшүүртэй байдлыг намжаах, «кампучийн асуудлыг» улс төрийн хэлэлцээний аргаар зохицуулах, АСЕАН-ы болон Энэтхэг-Хятадын хойгийн орнуудын хооронд энх тайван, сайн хөршийн харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэн бэхжүүлэх талаар БНСВУ, БНАЛАУ, БНКАУ-ын хамтран дэвшүүлсэн санал санаачилгыг хэрэгжүүлэх явдал чухал ач холбогдолтой юм. ЗХУ болон социалист хамтын нөхөрлөлийн бусад орон БНСВУ, БНХАУ-ын хоорондын маргаантай

асуудал, Энэтхэг-Хятадын хойгийн орнууд «кампучийн асуудал»-ыг энх тайван хэлэлцээний аргаар бүрэн шийдвэрлэж болох асуудал гэж үзэж байгаагаа удаа дараа мэдэгдсэн билээ. Харин ингэхдээ энэ районы улс орнуудын ард түмний төрийн тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, хувь заяагаа өөрсдөө сонгосон байдлыг хүндэтгэн үзэх үндсэн дээр гаднын ямар ч хүчний оролцоогүйгээр уг асуудал зохицуулагдан шийдвэрлэгдэх ёстой гэсэн зарчмыг манай орнууд хатуу баримталж байна.

Энэ оны 3-р сард ЗСБНХУ-ын гадаад явдлын яамны сайд Энэтхэг Хятадын хойгийн ах дүү гурван орон—БНСВУ, БНАЛАУ, БНКАУ, АСЕАН-ы том орон-Индонез, Номхон далайн өмнөд хэсгийн орон— Австралид айлчилсан нь Ази, Номхон далайн бүс нутгийн байдлыг эрүүлжүүлэх, тус бүс нутгийг олон улсын бүх нийтийн аюулгүй байдлын систем тогтооход хамран оруулахад чиглэсэн чухал үйл явдал болов. Энэтхэг-Хятадын хойгийн ах дүү гурван орны удирдагчидтай түүний хийсэн хэлэлцээний явцад БНСВУ, БНАЛАУ, БНКАУ-ын нам, засгийн газар Ази, Номхон далайн бүс нутагт болон дэлхий дахины тавцанд ЗХУ-ын явуулж буй энх тайванч бодлогыг бүрэн дүүрэн сайшаан дэмжиж байгааг ЗСБНХУ-ын гадаад явдлын яамны сайд, эдгээр орны удирдлагын хамтран гаргасан баримт бичгүүд харууллаа. Индонезийн засгийн газартай Зөвлөлтийн Гадаад явдлын яамны сайдын хийсэн хэлэлцээний явцад орчин үеийн олон чухал асуудал, тухайлан зэвсэглэлээр хөөцөлдөх явдлыг зогсоох асуудлаар тус хоёр орны баримталж буй байр суурь ойролцоо, ижил төстэй байгаа нь харагдаж, Ази, Номхон далайн бүс нутгийн энх тайван, аюулгүй байдлыг сахин бэхжүүлэх асуудлаар Владивостокт ЗХУКН-ын Төв Хорооны Ерөнхий нарийн бичгийн даргын хэлсэн үг, Зөвлөлт-Энэтхэгийн удирдагчдын хамтран гаргасан Делийн тунхаглалд тус бүс нутгийн болон дэлхий дахины аюулгүй байдлын асуудлаар тусгагдсан оновчтой үзэл санаануудыг Индонезийн тал дэмжив. Австралийн удирдлагатай Зөвлөлтийн Гадаад явдлын яамны сайдын хийсэн хэлэлцээний үед Номхон далайн өмнөд хэсгийг цөмийн зэвсэггүй бүс болгох талаар Австрали болон энэ хэсгийн бусад орны гаргаж байгаа чармайлтыг Зөвлөлтийн тал өндөр үнэлж байгаагаа, мөн ЗХУ Раротонгын гэрээнд нэгдэн орсноо мэдэгдэв.

Ази, Номхон далайн бүс нутгийн болон дэлхий дахины энх тайван, аюулгүй байдлыг сахин бэхжүүлэх үйлсэд эвсэлд үл нэгдэх хөдөлгөөн, түүний гол орон-Энэтхэг улс жинтэй хувь нэмэр оруулж байна. Үүнээс 30 гаруй жилийн өмнө Энэтхэг улс санаачилж тунхагласан нийгмийн янз бүрийн байгуулалтай улсууд энх тайвнаар зэрэгцэн орших «Панча-Ши ла»-гийн зарчим, Энэтхэг улсын идэвхтэй оролцоотойгоор Ази, Африкийн 29 орны гаргасан Бандунгийн Тунхаглалын 10 зарчим бол тэр цагаас хойш өнөөг хүртэл бусад орны дэвшүүлсэн олон тооны оновчтой санал санаачилгын хамт Ази, Номхон далайн бүс нутагт болон даян дэлхийд энх тайван, аюулгүй байдлын систем тогтоохын буурьтай үндэс болж өгөх чухал баримт бичгүүд мөн. Энэтхэг зэрэг олон орон оролцсон эвсэлд үл нэгдэх хөдөлгөөн дэлхийн янз бүрийн районд цөмийн зэвсэггүй бүсүүд байгуулахыг дэмжиж байгаагаараа Ази, Номхон далайн бүс нутгийг цаашид цэрэгжүүлэх явдлыг зогсоох, Энэтхэгийн далайн өргөн уудам районыг энх тайвны бүс болгох санал дэвшүүлж, энэ асуудлаар НҮБ-ын Ерөнхий Ассамблейн чуулганы шийдвэр гаргуулан, Энэтхэгийн далайг цөмийн зэвсгээс чөлөөтэй бүс болгохыг бүх улсуудад уриалсаар байна.

НҮБ Энэтхэгийн далайн асуудлаар олон улсын хурлыг зарлан хуралдуулах талаар удаа дараа шийдвэр гаргаж байсан боловч АНУ-ын тат-

галзсан зохисгүй байр сууриас болж, уг шийдвэр одоо хүртэл огт хэрэгжиж чадаагүй юм. Түүгээр ч барахгүй Энэтхэгийн далайд цэрэг зэвсэглэлийн үйл ажиллагааг хязгаарлаж, улмаар хорогдуулах тухай Зөвлөлт Америкийн хооронд 1977— 1978 онд явагдаж байсан хэлэлцээг АНУ дан гаараа дур мэдэн зогсоож, түүнийг сэргээхээс татгалзсан байна.

Социалист хамтын нөхөрлөлийн орнууд, ялангуяа ЗХУ дэлхий дахиныг хамарсан аюулгүй байдлын систем тогтоохын бүрэлдэхүүн хэсэг болсон Ази, Номхон далайн бүс нутагт аюулгүй байдлын систем бий болгох талаар өргөн хэмжээний цогцолбор программыг дэвшүүлэн тавихдаа тус бүс нутаг дахь улс төр, эдийн засаг, цэрэг-стратегийн болон улс үндэстний, шашин шүтлэгийн ба бусад зөрчил маргаанаас үүдэн гарч буй ихээхэн бэрхшээлийг тодорхой ойлгож байгаагийн зэрэгцээ, у хэрэв холбогдох бүх сонирхогч улсууд сайн санаа өвөрлөж, хамтын хүч чадлаа дайчилбал, энэ бүс нутгийн байдал хичнээн ээдрээтэй, зөрчил тэмцэл, маргаантай байлаа ч гэсэн, дээр дурдсан бэрхшээл саадыг даван туулж, Ази, Номхон далайн бүс нутагт аюулгүй байдлын систем тогтоох асуудлаар харилцан хүлээж авч болохуйц шийдвэрийг гаргаж чадна гэсэн итгэл найдвар, ажил хэрэгч бодит хандлагадаа тулгуурлан бодлогоо явуулдаг юм. Ийм бодлогыг баримтлахдаа манай орнууд хоёр том бүлэг үзэл санааг дэвшүүлэн тавьж байна. Үүнд: **нэгдүгээрт**, Тус бүс нутгийн улс орнуудын хоорондын харилцаа, энд байгаа маргаан, зөрчлүүдийг зохицуулан шийдвэрлэх хандлагын ерөнхий зарчмуудыг боловсруулахад анхаарч, энэ талаархи бүхий л оновчтой санал, санаачилга, туршлагыг нэгтгэн дүгнэж, тэдгээрт тулгуурлахыг голчилж байна. **Хоёрдугаарт**, бүс нутгийн болон салбар бүс нутаг, хоёр талын түвшинд төрөл бүрийн цогцолбор практик арга хэмжээ, алхмуудыг авч, тэдгээрийг харилцан зөвшөлцөж хэрэгжүүлснээр нийт бүс нутгийн улс төрийн уур амьсгалыг аажмаар эрүүлжүүлж, эндэхийн улс орнуудын хооронд харилцан итгэлцэл, олон талын ашигтай хамтын ажиллагааг өргөтгөн хөгжүүлэхэд шийдвэрлэх эргэлт хийж болох юм гэсэн өөдрөг үзэл бодолтой байдаг юм.

Социализмын ах дүү орнууд цөмийн пуужинт зэвсгийн эрин үеийн шаардлагаас үүдэн гарч буй ноцтой байдалд шинэ сэтгэлгээгээр хандан, сөргөлдөөнийг улам хурцатган дэвэргэж байгаа империалист харгис хүчний дайнч түрэмгий бодлогод нийт олон улсын, түүний дотор Ази, Номхон далайн бүс нутгийн түгшүүртэй байдлыг намжааж, энх тайван, аюулгүй байдлын систем тогтооход чилгэсэн зарчимч тууштай гадаад бодлого баримталж байна.

МАХН, БНМАУ-ын засгийн газар социалист хамтын нөхөрлөл, Азийн социалист орны хувьд цаашид Ази, Номхон далайн бүс нутгийн улс орнуудын улс төр, олон нийтийн хамгийн янз бүрийн хүчний төлөөлөгчдийг оролцуулан өргөн уулзалт зохиох тухай санал дэвшүүлж, хөгжлийн түвшин, нийгмийн байгууллагыг харгалзахгүйгээр том, дунд, жижиг бүх улсуудыг тус бүс нутаг дахь маргаантай байгаа асуудал, зөрөлдөөнийг хэлэлцэн тохиролцох аргаар хамтын чармайлтаар зохицуулж шийдвэрлэн, түүний аюулгүй байдлын систем тогтоохын төлөө идэвхтэй үйл ажиллагаа явуулж байна. Зэвсэглэлээр хөөцөлдөх явдлыг зогсоож, цөмийн сүйрлийг сэрэмжлэн зайлуулан, аюулгүй байдлыг найдвартай хангах нь тус бүс нутгийн орон бүр, дэлхийн нийт улсуудын амин эрх ашигт нийцсэн орчин үеийн нэн чухал асуудал мөн.